

## **1. ХЧМЗ ТББ-ын танилцуулга, зорилго, зорилт**

### **Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл ТББ**

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ (Зөвлөл) нь хилийн чанад дахь монгол иргэдийн үүсгэн байгуулсан ТББ-уудын нэгдсэн зөвлөл бөгөөд эхорныхоо хөгжил, гадаад сурталчилгаанд нэгдсэн бодлогоор хувь нэмэр оруулж, төр засагтай нэгдсэнсүвгаар харилцаж, хамтран ажиллах зорилготой байгууллага билээ.

Зөвлөл нь 2014 оны 9 сарын 18- д Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдсан „Бүтээлч хамтын ажиллагаа“ - Хилийн чанадад дахь монголчуудын ТББ-уудын анхдугаар чуулга уулзалтын дараа хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, Монгол улсын төр, засгийн байгууллагуудтай харилцах үйл ажиллагаагаа оновчтой хэлбэрт орох нь зүйтэй хэмээн санал нэгтэй нэгдэн 2014 оны 9 сарын 19-ны хилийн чанадад дахь ТББ-уудаас нийт 41 төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр үүсгэн байгуулагдсан түүхтэй.

Үүсгэн байгуулагдсанаас хойш Хилийн чанад дахь Монгол иргэд, тэдний холбоо, байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээн сурталчлах, гишүүн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэдгээрийг чадваржуулах, төсөл хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг үзүүлэх зорилго чиглэлийг баримтлан ажиллаж байна. Бид хилийн чанадад шилжин суурьшсан Монголчуудын хоорондын харилцаа, нэгдмэл цогц бодлого хэрэгжүүлэх, тэдний тэдний мэдлэг, боловсрол, үйл ажиллагаа, харилцаа холбоогоор эх орныхоо бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулахыг дэмжсэн ажлуудыг хэрэгжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна.

## 2. ХЧМЗ ТББ-ын бүтэц

# Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн бүтэц шинэчилсэн байдлаар



### Зөвлөлийн бүх гишүүдийн хурал

Гишүүн байгууллагуудын эрх бүхий төлөөлөл  
/ээлжит хурал 2 жил тутамд/

### ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛ

Улс орон бүрээс монголчуудын тоо, үйл ажиллагаа явуулж буй холбоодын тооноос хамваран  
33 хүртэл гишүүнтэй байна. /БХЗА ээлжит хурал 3 сар тутамд/

БХЗА-нд 6 сараас дээш хугацаагаар идэвхтэй ажилласан гишүүн УЗ-д нэр дэвшигдэх эрхтэй

### УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Холбоо, үйл ажиллагааны чиглэл болон улс орны харьяалааас үл хамваран  
11-аас 15 хүртэлх тооны сондгой тооны гишүүн байна.

#### Хяналтын алба

3 гишүүн

#### Үндсэн чиглэлийн хороо

Боловсролын хороо  
Нийгмийн Бодлогын Хороо  
Соёл, урлаг, аялал жуулчлалын менежментийн хороо  
Бизнес хөгжлийн хороо  
Оюутан, залуучуудын хороо  
Спортын хороо

#### Ажлын алба

Удирдах зөвлөлийн тэргүүн  
Ерөнхий нарийн бичгийн дарга  
Гишүүнчлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах гишүүн

**.Хилийн Чанад дахь Монголчуудын Зөвлөл ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн товч мэдээлэл**

(2017-2019 хугацаанд сонгогдон ажиллах гишүүд)  
(2017-2020

✚ ХЧМЗ ТББ-ын тэргүүн -**Н. Номун-Эрдэнэ**, Швед улс Стокгольм хотноо оршин суугаа.

Н. Номун-Эрдэнэ нь :

- Швед дэх Монголчуудын Үндэсний Холбооны тэргүүнээр 2011-2015
- ХЧМЗ ТББ-ын тэргүүн 2014.09.18 -2016.01
- ХЧМЗ ТББ-ын Зөвлөх 2016.01 -2016.10
- ХЧМЗ ТББ-ын Нийгмийн бодлогын Хорооны даргаар 2016.10- 2017.06.23 хугацаанд ажиллаж байсны зэрэгцээ мөн
- Швед дэх Монголчуудын ТББ-уудын Нэгдсэн Зөвлөлийн ерөнхий зохицуулагч 2017.05
- ХЧМЗ ТББ-ын тэргүүнээр 2017.06 сараас эхлэн ажиллаж буй болно.



✚ ХЧМЗ ТББ-ын Хяналтын Зөвлөлийн дарга- **М. Найданхүү**, Монгол Улс Улаанбаатар хотноо оршин суугаа.



✚ ХЧМ ТББ-ын Тэргүүний Зөвлөх- Ш.Баатар, Сан Франциско хотноо оршин суугаа. Ш.Баатар нь Бэй Аэриагийн Монголчуудын Холбоо ны Удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг.



✚ ХЧМЗ ТББ-ын тэргүүний зөвлөх - Д.Цэрэнбат Их Британи улс, Лондон хотноо оршин суугаа.

Д.Цэрэнбат нь мөн:

- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн
- Цахим Өртөө Холбоо ТББ-ын тэргүүн
- “Британийн Монголчуудын Холбоо” -ны тэргүүнээр мөн ажиллаж буй болно.



✚ ХЧМЗ ТББ-ын Зөвлөх- **Б. Мөнхдөл**, Монгол Улс Улаанбаатар хотноо оршин суугаа.

Б.Мөнхдөл нь мөн :

- Цахим Өртөө Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн
- Японд төгсөгчдийн Жугамо холбооны Удирдах зөвлөлийн гишүүн
- 11-р сургууль төгсөгчдийн холбооны тэргүүн
- Канад-Монголын худалдааны танхимын Удирдах зөвлөлийн гишүүн
- Cover Mongolia компанийг үндэслэгч, ерөнхий захирлаар тус тус ажилладаг ба
- ХЧМЗ ТББ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар 2014 оны 10 сараас эхлэн томилогдон ажиллаж байгаа.



**1. ХЧМЗ ТББ-ын Тэргүүний Хуулийн бодлогын зөвлөх Л.ОТГОНБАЯР Монгол Улс Улаанбаатар хотноо оршин суугаа.**

ХЧМЗ ТББ-ын Тэргүүний Хуулийн бодлогын зөвлөхөөр Л.ОТГОНБАЯР

- 2016-2018 онуудад Монгол Улсаас ИБУИНВУ-д суугаа Элчин сайдын яамны иргэд, консул, боловсрол, соёлын асуудал хариуцсан зөвлөх
- 2016-2017 онуудад Лондонд төвтэй Олон Улсын Далайн Байгууллага дахь Байнгын төлөөлөгч
- [www.legal-policy.mn](http://www.legal-policy.mn) хууль зүйн фирмийн зөвлөх
- Цахим Өртөө Холбооны гишүүнээр ажиллаж буй болно.



**ХЧМЗ ТББ-Зөвлөх Ж. Өнөрмаа, ИБУИНВУ Лондон хотноо оршин суугаа.**

Ж. Өнөрмаа нь:

- Европ, Монголын Нийгэмлэг Дэд тэргүүн 2011-2016
- Лондон хотын Зүүн Азийн уран бүтээлчдийн дунд зарладаг Уран баримлын уралдаан Зөвлөх комиссын гишүүн 2012- 2017
- Лондон Хотын Үндэстэн Хоорондын Соёлын Нийгэмлэг УЗ-ийн гишүүн 2009 – 2010 оны хооронд ажиллаж байсны зэрэгцээ
- Монгол Улсын Гадаад харилцааны яам Монгол Улсын Соёлын элч 2015 оноос одоог хүртэл
- Цахим өртөө ТББ-ын гишүүн 2008 оноос одоог хүртэл
- Британийн Монголчуудын Холбооны УЗ-ийн гишүүн 1999 оноос одоог хүртэл
- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн Гишүүн, Соёлын урлагын хорооны даргаар 2014 оноос 2018 он хүртэл ажилласан.



3. Ариунтэнгэр-ХЧМЗ ТББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга гишүүн, Монгол Улс, Улаанбаатар хотноо оршин суугаа.

3. Ариунтэнгэр нь:

- Бээжин дэх Монгол Оюутны Холбоо тэргүүн 2011-2013
- БНХАУ дахь МОХ ерөнхийлөгчөөр 2014-2017 оны оны хооронд ажиллаж байсны зэрэгцээ
- Хятадад Төгсөгч, Суралцагчдын Холбооны холбоо Гүйцэтгэх захирал 2016 оноос одоог хүртэл ажиллаж буй болно.



4. А. Долгион- ХЧМЗ ТББ-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Япон улс Чика хотноо оршин суугаа.

А. Долгион нь мөн:

- “Халуун Сэтгэл in Japan” ТББ (Япон улс Токио хот) Үүсгэн байгуулагч, Тэргүүн 2013-2016 онуудад ажиллаж байсны зэрэгцээ
- “Япон дахь Монгол Иргэдийн Нэгдсэн Холбоо” ТББ (Япон улс Токио хот) тэргүүнээр 2016 оноос одоог хүртэл ажиллаж байгаа.



### **ХЧМЗ ТББ-ын хороодын дарга нар:**

✚ ХЧМЗ ТББ-ын Бизнесийн хөгжлийн хорооны дарга- **Б.Энхтүвшин**, ХБНГУ Берлин хотноо оршин суугаа.

Б.Энхтүвшин нь :

- Берлин Цог Монгол спорт клуб ТББ-ын Хэвлэл мэдээллийн албанд 2010- 2015
- Монгол Германы эдийн засгийн клуб ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга 2013-2016
- ХЧМЗ ТББ-ын тэргүүн 2016.01- 2017.06
- ХБНГУ дахь Монгол-Германы ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргаар 2015- 2017 оны хооронд ажиллаж байсны зэрэгцээ мөн
- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн
- Монголчууд Германд Мэдээллийн суваг ТББ-ын үндсэн зохицуулагчаар 2009 оноос одоог хүртэл ажиллаж буй болно.



✚ ХЧМЗ ТББ-ын Боловсролын хорооны дарга- Ө.Оюунтүлхүүр, ХБНГУ Штуттгарт хотноо оршин суугаа.

Ө.Оюунтүлхүүр нь :

- Герман хүмүүст зориулан монгол хэлний ганцаарчилсан болон онлайн хувийн сургалтын багш 2000 оноос одоог хүртэл
- “Солонго” монгол хэл, соёлын сургуулийн багш, захирал 2009 оноос одоог хүртэл
- VMA- Монгол академичдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн 2014 оноос одоог хүртэл
- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн Гишүүн, Боловсролын хорооны дарга 2015 оноос одоог хүртэл
- “Энх-удам” Европын аялал жуулчлалын хувийн компанийг 2012 оноос одоог хүртэл ажиллуулж байгаа.



✚ ХЧМЗ ТББ-ын Нийгмийн бодлогын хорооны дарга- С.Цэрэндэмбэрэл, Польш улс, Варшав хотноо оршин суугаа.

С.Цэрэндэмбэрэл нь мөн :

- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн
- ХЧМЗ ТББ-ын Нийгмийн Бодлогын хорооны дарга.
- БНПУ дахь Монгол хэл, соёлын төвийн тэргүүнээр тус тус ажиллаж буй болно.





✚ П. Майнбаяр- ХЧМЗ ТББ-ын Соёл урлагын хорооны дарга

П. Майнбаяр нь мөн:

- БНСУ дахь Монгол Эмэгтэйчүүдийн холбоо Ажлын албаны дарга 2010-2017
- Эмэгтэйчүүд гэр бүлийн яам Сөүл хотын төлөөлөгч 2015-2017
- Сөүл хотын гадаад иргэдийн төлөөлөгч Монгол Улсын төлөөлөгчөөр 2015-2017

тус тус ажиллаж байгаа.



✚ ХЧМЗ ТББ-ын Оюутан залуучуудын хорооны дарга-Б. Энхгэрэл, Тайвань улс Тайбэй хотноо оршин суугаа.

Б. Энхгэрэл нь:

- Тайвань дахь Монгол Оюутан залуучуудын дэмжих Холбоо тэргүүнээр 2015-2016 оны хооронд ажиллаж байсны зэрэгцээ
- Хөдөө аж ахуйн их сургууль, Инновац бизнес хөгжлийн төв Гадаад харилцааны зөвлөх 2017 оноос одоог хүртэл
- Монгол Тайваний бизнес эрхлэгчдийн хөгжлийн сан Гүйцэтгэх захирал 2014 оноос одоог хүртэл
- ХЧМЗ ТББ-ын УЗ гишүүн, Оюутан залуучуудын хорооны дарга 2014 оноос одоог хүртэл ажиллаж буй болно.



## Бусад Удирдах Зөвлөлийн Гишүүд:

✚ Д.Амарбаясгалан- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, ОХУ Москва хотноо оршин суугаа

Д.Амарбаясгалан нь мөн:

- Мөнх Тэнгэр Холбоо тэргүүн 2002 оноос одоог хүртэл
- Монгол Ахан Дүүсийн Холбооны тэргүүнээр 2002 оноос одоог хүртэл ажиллаж буй болно.



✚ Л.Алтанчимэг- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, Бельги улс Антверпен хотноо оршин суугаа .

Л.Алтанчимэг нь мөн:

- Бельги улс дахь Азийн Холбооны Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн 2016 оноос одоог хүртэл
- Европ-Монгол Нийгэмлэгийн тэргүүн 2016 оноос одоог хүртэл
- Бельгийн Вант Улс дахь "Эв нэгдэл" холбооны тэргүүнээр 2009 оноос одоог хүртэл ажиллаж буй болно.



✚ Ц.Батсоёмбо- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн АНУ, Сан Франциско хотноо оршин суугаа.

Ц.Батсоёмбо нь мөн:

- АНУ дахь Бэй Аэриагийн Монголчуудын Холбооны УЗГ 2006-2012
- АНУ дахь Бэй Аэриагийн Монголчуудын Холбооны тэргүүнээр 2012-2017 онуудад ажиллаж байгаа.



✚ Л. Ира- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн , БНСУ Соннам хотноо оршин суугаа

, Ира нь :

- БНСУ дахь Монгол эмэгтэйчүүдийн холбооны Үүсгэн байгуулагч, зөвлөх 2010-2012 онуудад ажиллаж байсны зэрэгцээ
- БНСУ дахь Монгол иргэдийн холбооны тэргүүн 2014 оноос одоог хүртэл
- NISS-Asia ХХК ТУЗ-ын дарга
- БНСУ дахь Монголчуудын ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргаар тус тус ажилладаг.



- ✚ Мэдээлэл харилцааны албаны дарга: О.Адьяасүрэн, БНХАУ Бээжин хотноо оршин суугаа.

О.Адьяасүрэн мөн

- БНХАУ дахь МОХ зөвлөх 2015-2016
- ХЧМЗ ТББ-ын Нийгмийн Бодлогын Хорооны зохицуулагчаар 2016-2017 оны хооронд ажиллаж байсан ба
- ХЧМЗ ТББ-ын Мэдээлэл харилцааны албаны даргаар 2017 оноос одоог хүртэл ажиллаж байгаа.



- ✚ Б.Цэрэнбат - ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, АНУ Чикаго хотноо оршин суугаа

Б.Цэрэнбат нь:

- АНУ-ын Чикаго хот дахь Америк- Монголын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн.
- [chicagomongols.com](http://chicagomongols.com) сайтыг үүсгэн байгуулагч, админ нь ажилладаг ба 2017 оноос эхлэн “Чикаго Монгол Төв”-ийг үүсгэн байгуулахаар ажиллаж байгаа.



- ✚ Г.Эрдэнцэцэг- ХЧМЗ ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, Австраль улс, Сидней хотноо оршин суугаа

Г.Эрдэнцэцэг нь:

2010-2018 оноос Австраль дахь Монголчуудын Холбооны дэр тэргүүнээр ажиллаж байгаа.

### **ХЧМЗ ТББ-ын Ерөнхий Нарийн Бичгийн дэргэдэх ажлын алба**



Д.Амараа /ХЧМЗ НБХ-ны гишүүн/

- 2014-2017 ХЧМЗ ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн
- 2014 онд Бельги дэх Монголчуудын Нэгдсэн Холбоог үүсгэн байгуулагч
- 2016 оноос Дэлхийн Монгол Эмэгтэйчүүдийн Хүмүүнлэгийн Академийн Ерөнхийлөгч
- 2014 оноос Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүнээр одоор хүртэл ажиллаж байна

Э.Бум /ХЧМЗ ТББ Хэвлэл Мэдээлэл Хариуцсан нарийн бичгийн дарга

- 2016-2017 МҮОНРТВ ийн тусгай сурвалжлагч



Дашийн Нямсүрэн, /Боловсролын Хорооны Гишүүн/



- 1994-2001 онд МАСА-Монгол Америкийн соёлын холбооны Монгол дахь төлөөлөгч
- 2006-2011 онд АНУ-ын нийслэл дэх Монгол сургуулийг үүсгэн байгуулж удирдан ажилласан.
- 2011 оноос өнөөг хүртэл тус сургуулийн Монгол дахь төлөөлөгч, DASH-Дэмжлэг амжилт сайн хүн ТББ-ын гүйцэтгэх захирал, ХЧМЗ-ийн Боловсролын хороог төлөөлөн ажиллаж байна.